



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 4582

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөвт батлах тухай” 05/07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2021 оны төсөвт батлах тухай” 2020 оны 03/07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 2.3 дахь заалтад тусгагдсан Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардлыг хуваарилсан аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/437 дугаар захирамжийн хавсралтын 1-т тусгагдсан “Баянтээг түлш” ОНӨХХК-ний ажилчдын амрах байр, хоолны газар, халуун ус, ариун цэврийн байгууламжийн зардал 65,500,000 (жаран таван сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулах эрхийг “Баянтээг түлш” ОНӨХХК (Д.Азбилэг)-т шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг “Баянтээг түлш” ОНӨХХК (Д.Азбилэг)-т үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



• 011101226